

**ГХБХБГ-ЫН 9 ДҮГЭЭР САРЫН 2 ДАХЬ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,
СУДАЛГАА**

2018.09.13.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>1 иргэний газрын маргаанд очиж ажилласан, мөн ГЗБГЗЗГ-т газрын төлбөр татвар, үнэлгээний тухай санал хүргүүлсэн.</p> <p>ГХБХБГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Сагсай сум, Ногооннуур сум, Цагааннуур тосгонд газрын харилцааны хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шинжилгээ мониторингийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Гарсан алдаа дутагдлыг арилгах талаар тухай сум орон нутгийн удирдлагуудад зөвлөгөө өгч ажилласан болно.</p> <p>Дэлүүн сумын 150 хүүхдийн барилгад хяналт хийсэн. Сагсай сумын сургуулийн халуун ус, Хазна ХХК-ний аймгийн төвд нефтийн агуулах, ШТС, Ногооннуур сумын Улаан-чулуу багийн 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгуудын эхлэх зөвшөөрлийг зохих журмын дагуу олгосон байна.</p> <p>Орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар аймгийн саналыг БХБЯаманд хүргүүлэв.</p> <p>Дэлүүн сумын дотуур байр, Сагсай сумын 125 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэл далд актын ажлыг баталгаажуулав.</p> <p>“Өлгийланд” ХХК-ны хийсэн 14 иргэн, “Эл эм ланд” ХХК-ны хийсэн 6 аж ахуйн нэгж байгууллагын нийт 20 иргэн аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил газрын газрын хэмжилтийн мэдээллийг хүлээн авч кадастрын мэдээллийн санд оруулсан болно.</p> <p align="center">Цэнгэл сумын газрын</p>	<p align="center">Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

даамлын компьютерыг форматалж, хэрэглээний болон мэргэжлийн программ хангамжийг суулган газрын кадастрын мэдээллийн санг сэргээж, компьютерын хэвийн ажиллагааг хангаж өгч, Цэнгэл сумын газрын даамалд хүлээлгэж өгөв.

Баян-Өлгий аймгийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, Мөн 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд саналаа бичиж аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.

Сумдын газрын даамлуудаас тогтмол 7 хоногийн мэдээ авч ажиллаж байна. **Тухайлбал:**

Өлгий сум: Өлгий сумын хэмжээнд байгаа геодезийн бүх цэг тэмдэгтийн тооллого хийж, судалгааг нь гаргаж газрын даргад танилцуулсан.

гэрээний дагуу тухайн газрыг зориулалтын дагуу ашиглаагүй 42 иргэн, ААНБайгууллагын хүчингүй болгох жагсаалтыг гаргав.

Бугат сум: 6 иргэний өргөдөл хүлээн авсан. Сумын төвийн 4 иргэний газрыг тодруулж тэмдэглүүлж өгөв. 3 хүний өмчлөлийн материал бүрдүүлж цахим хувийн хэрэгт холбосон. 2 иргэний үл хөдлөх хөрөнгийн материал бүрдүүлэв. Сумын 2-р багийн 4 иргэний өвөлжөөний кадастрын зургийг хийж гүйцэтгэсэн болно.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР